

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2025/139-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум</p> <p>2025 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг Цагаан эрэг Сүхбаатар сум  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976) 7036 3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.АЛТАНТУЯА ТАНАА

2025.06.20 № СЭА-2025/139-НА-СТА-ТШЗ  
хувий -ийг № -ийг

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын төсвөөс боловсролын байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 72 албан хаагчид 1,614,314.2 мянган төгрөгийг, хөдөө орон нутагт тогтвор ажилласан 722 албан хаагчид 5,392,606.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

### Аудитын гол асуудал

Тус газрын батлагдсан 30 орон тооноос нөхөгдөхгүй байгаа 10 ажлын байрыг бусад албан хаагчдаар хавсран гүйцэтгүүлж байгаа бөгөөд үүнээс нягтлан бодогчийг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнээр "Хөдөлмөрийн гэрээ"-ний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 83.1 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,724,249.00</b>	<b>15,454,779.00</b>
33	<b>АВЛАГА</b>	4,500,000.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,500,000.00	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,224,249.00	15,454,779.00
354	<b>Хангамжийн материал</b>	12,224,249.00	15,454,779.00
35410	Бичиг хэргийн материал	251,870.00	-
35420	Аж ахуйн материал	11,447,379.00	12,339,779.00
35440	Түлш, шатах тослох материал	525,000.00	2,425,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	690,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>94,651,979.75</b>	<b>206,448,274.10</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	94,651,979.75	206,448,274.10
392	<b>Биет хөрөнгө</b>	94,651,979.75	206,448,274.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,557,455.35)	(24,157,455.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,280,084.97	264,622,404.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(179,616,525.86)	(89,064,190.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,485,009.75	26,485,009.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,414,133.76)	(5,912,494.84)
39217	Ном	875,000.00	875,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>111,376,228.75</b>	<b>221,903,053.10</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>111,376,228.75</b>	<b>221,903,053.10</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	111,376,228.75	221,903,053.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,787,128.44	211,787,128.44
51101	Өмч: - төрийн	211,787,128.44	211,787,128.44
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(100,410,899.69)	10,115,924.66
51210	Өмнөх үеийн үр дүн	(29,191,191.38)	(100,410,899.69)
51220	Тайлант үеийн үр дүн	(71,219,708.31)	110,526,824.35
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>111,376,228.75</b>	<b>221,903,053.10</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,195,594,172.26</b>	<b>8,809,296,626.45</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>306,997,730.26</b>	<b>717,198,118.75</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	306,997,730.26	717,198,118.75
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,489,121.84	167,339,698.75
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	305,508,608.42	549,858,420.00
13	<b>ТУСПАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,888,596,442.00</b>	<b>8,092,098,507.70</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,773,748,100.00	8,017,528,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,773,748,100.00	8,017,528,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	114,848,342.00	74,570,407.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,975,000.00	51,285,007.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,444,942.00	23,285,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	428,400.00	-

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,258,364,593.07</b>	<b>8,698,769,802.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,258,364,593.07</b>	<b>8,698,769,802.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,075,520,218.72	1,426,668,531.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	463,109,113.53	602,156,644.36
210101	Үндсэн цалин	282,035,866.89	355,161,548.97
210102	Нэмэгдэл	105,741,649.42	178,054,596.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,001,361.64	30,427,277.08
210104	Урамшуулал	37,330,235.58	38,513,221.92
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,194,579.44	74,472,416.52
210201	Тэтгэврийн даатгал	39,625,878.35	52,080,915.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,673,585.16	6,127,166.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,712,468.12	3,020,683.29
210204	Ажилгүйдлийн даатгал	834,786.10	2,648,730.25
210205	Эрүүл мэндийн даатгал	8,347,861.71	10,594,920.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,170,607.28	33,676,965.77
210301	Гэрэл, цахилгаан	3,508,443.28	4,153,116.77
210302	Түлш, халаалт	27,862,574.00	27,866,149.00
210303	Цэвэр, бохир ус	799,590.00	1,657,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	313,902,967.37	565,676,050.00
210401	Бичиг хэрэг	2,004,080.00	4,573,770.00
210402	Тээвэр, шатахуун	3,843,000.00	9,006,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	427,039.95	734,910.00
210404	Ном, хэвлэл	91,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,881,400.00	1,318,950.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	305,436,047.42	549,822,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,754,400.00	2,117,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	48,000.00
210604	Урсгал засвар	1,754,400.00	2,069,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	76,999,622.00	15,046,100.00
210702	Дотоод албан томилолт	76,999,622.00	15,046,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,489,010.00	45,786,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,197,640.00	45,592,290.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,120.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	126,899,919.10	87,736,814.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	706,000.00	1,060,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,350,606.45	27,033,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	88,843,312.65	59,643,304.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,182,844,374.35	7,272,101,271.05
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,046,442,823.00	7,072,983,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,240,243,239.00	1,614,314,214.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,804,338,084.00	5,458,354,266.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,861,500.00	315,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	136,401,551.35	199,117,791.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	134,984,457.30	194,074,640.38
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,417,094.05	5,043,150.67
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(62,770,420.81)</b>	<b>110,526,824.35</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,449,287.50	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,449,287.50	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(8,449,287.50)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(71,219,708.31)</b>	<b>110,526,824.35</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,889,646,442.00</b>	<b>8,096,598,507.70</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,889,646,442.00</b>	<b>8,096,598,507.70</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,773,748,100.00	8,017,528,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,773,748,100.00	8,017,528,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	115,898,342.00	79,070,407.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,975,000.00	51,285,007.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,444,942.00	23,285,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,478,400.00	4,500,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,871,346,542.00</b>	<b>8,092,498,607.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,871,346,542.00</b>	<b>8,092,498,607.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>683,897,167.65</b>	<b>820,397,336.65</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	462,985,305.27	602,156,644.36
210101	Үндсэн цалин	281,912,058.63	355,161,548.97
210102	Нэмэгдэл	105,741,649.42	178,054,596.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,001,361.64	30,427,277.08
210104	Урамшуулал	37,330,235.58	38,513,221.92
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,318,387.70	74,472,416.52
210201	Тэтгэврийн даатгал	39,749,686.61	52,080,915.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,673,585.16	6,127,166.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,712,468.12	3,020,683.29
210204	Ажилгүйдлийн даатгал	834,786.10	2,648,730.25
210205	Эрүүл мэндийн даатгал	8,347,861.71	10,594,920.83
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,170,607.28	33,676,965.77
210301	Гэрэл, цахилгаан	3,508,443.28	4,153,116.77
210302	Түлш, халаалт	27,862,574.00	27,866,149.00
210303	Цэвэр, бохир ус	799,590.00	1,657,700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,865,789.95	17,544,560.00
210401	Бичиг хэрэг	2,255,950.00	4,321,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,868,000.00	10,906,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	427,039.95	734,910.00
210404	Ном, хэвлэл	91,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,003,400.00	1,361,750.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,011,400.00	2,967,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,741,000.00	897,600.00
210604	Урсгал засвар	1,270,400.00	2,069,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	76,999,622.00	15,046,100.00
210702	Дотоод албан томилолт	76,999,622.00	15,046,100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,589,010.00	45,786,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,297,640.00	45,592,290.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,120.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,957,045.45	28,747,510.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	706,000.00	1,060,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,251,045.45	27,687,510.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,187,449,374.35</b>	<b>7,272,101,271.05</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,046,547,823.00</b>	<b>7,072,983,480.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,240,243,239.00	1,614,314,214.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,804,338,084.00	5,458,354,266.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,966,500.00	315,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	140,901,551.35	199,117,791.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	134,984,457.30	194,074,640.38
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,917,094.05	5,043,150.67

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,299,900.00	4,099,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,299,900.00	4,099,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,299,900.00	4,099,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,299,900.00	4,099,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,299,900.00	4,099,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(18,299,900.00)	(4,099,900.00)

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,787,128.44	(29,191,191.38)	182,595,937.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	(29,191,191.38)	182,595,937.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(71,219,708.31)	(71,219,708.31)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	(100,410,899.69)	111,376,228.75
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,787,128.44	(100,410,899.69)	111,376,228.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	(100,410,899.69)	111,376,228.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	110,526,824.35	110,526,824.35
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	10,115,924.66	221,903,053.10

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,017,528,100.00	7,823,453,459.62	194,074,640.38	97.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,017,528,100.00	7,823,453,459.62	194,074,640.38	97.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	838,939,500.00	750,469,979.62	88,469,520.38	89.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,603,600.00	556,473,814.08	75,129,785.92	88.10
210101	Үндсэн цалин	357,523,400.00	355,161,548.97	2,361,851.03	99.34
210102	Нэмэгдэл	202,555,700.00	132,371,766.11	70,183,933.89	65.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,337,100.00	30,427,277.08	909,822.92	97.10
210104	Урамшуулал	40,187,400.00	38,513,221.92	1,674,178.08	95.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,700,400.00	68,870,239.77	9,830,160.23	87.51
210201	Тэтгэврийн даатгал	53,516,300.00	48,197,875.20	5,318,424.80	90.06
210202	Тэтгэмжийн даатгал	6,296,000.00	5,670,338.08	625,661.92	90.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,148,000.00	2,792,269.11	355,730.89	88.70
210204	Ажилгүйдлийн даатгал	3,148,000.00	2,441,951.49	706,048.51	77.57
210205	Эрүүл мэндийн даатгал	12,592,100.00	9,767,805.89	2,824,294.11	77.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,024,100.00	33,676,965.77	347,134.23	98.98
210301	Гэрэл, цахилгаан	4,442,200.00	4,153,116.77	289,083.23	93.49
210302	Түлш, халаалт	24,912,900.00	27,866,149.00	(2,953,249.00)	111.85
210303	Цэвэр, бохир ус	4,669,000.00	1,657,700.00	3,011,300.00	35.50
2104	Хангамж, бараа материалын зардал	14,771,700.00	14,757,260.00	14,440.00	99.90
210401	Бичиг хэрэг	1,104,300.00	2,414,600.00	(1,310,300.00)	218.65
210402	Тээвэр, шатахуун	10,960,600.00	10,026,000.00	934,600.00	91.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	722,900.00	734,910.00	(12,010.00)	101.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	667,400.00	220,000.00	447,400.00	32.96
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд зүйлс	1,316,500.00	1,361,750.00	(45,250.00)	103.44

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,070,400.00	7,067,000.00	3,400.00	99.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,997,500.00	2,500.00	99.95
210604	Урсгал засвар	2,070,400.00	2,069,500.00	900.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	9,329,600.00	9,306,300.00	23,300.00	99.75
210702	Дотоод албан томилолт	9,329,600.00	9,306,300.00	23,300.00	99.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,263,300.00	43,286,040.00	1,977,260.00	95.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,560,900.00	43,092,290.00	1,468,610.00	96.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	436,300.00	-	436,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	119,500.00	119,250.00	250.00	99.79
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,400.00	52,500.00	38,900.00	57.44
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,200.00	22,000.00	33,200.00	39.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,176,400.00	17,032,360.00	1,144,040.00	93.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,305,700.00	1,060,000.00	245,700.00	81.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,870,700.00	15,972,360.00	898,340.00	94.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,178,588,600.00	7,072,983,480.00	105,605,120.00	98.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,178,588,600.00	7,072,983,480.00	105,605,120.00	98.53
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,687,206,400.00	1,614,314,214.00	72,892,186.00	95.68
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,491,066,800.00	5,458,354,266.00	32,712,534.00	99.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	315,400.00	315,000.00	400.00	99.87
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>8,017,600,100.00</b>	<b>7,823,453,459.62</b>	<b>194,146,640.38</b>	<b>97.58</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>8,017,600,100.00</b>	<b>7,823,453,459.62</b>	<b>194,146,640.38</b>	<b>97.58</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,017,600,100.00	7,823,453,459.62	194,146,640.38	97.58
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>30.00</b>	<b>18.00</b>	<b>12.00</b>	<b>60.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	-	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	11.00	10.00	52.38
620003	Үйлчлэх ажилтан	8.00	7.00	1.00	87.50
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>30.00</b>	<b>17.00</b>	<b>13.00</b>	<b>56.67</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22.00	10.00	12.00	45.45
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	8.00	7.00	1.00	87.50

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>79,070,407.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>79,070,407.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>74,027,257.03</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>45,682,830.28</b>
210102	Нэмэгдэл	45,682,830.28
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,602,176.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,883,040.53
210202	Тэтгэмжийн даатгал	456,828.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	228,414.18
210204	Ажилгүйдлийн даатгал	206,778.76
210205	Эрүүл мэндийн даатгал	827,114.94
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,787,300.00</b>
210401	Бичиг хэрэг	1,907,300.00
210402	Тээвэр, шатахуун	880,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,739,800.00
210702	Дотоод албан томилолт	5,739,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,715,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,715,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,043,150.67
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,043,150.67</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,043,150.67
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	79,070,407.70
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	79,070,407.70
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,285,007.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,285,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,500,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Боловсролын газар /цаашид Боловсролын газар гэх/ нь 2024 онд “Иргэн бүрийг бие даан суралцах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, технологийг хүртээмжтэй, чанартай олгоно” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Салбарын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах, өөрчлөх, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох.
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх.
- Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох эрх зүйн баримт бичигт заасны дагуу эрх бүхий байгууллагад гаргаж өгөх.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
- Харьяаны ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загвар батлах.
- Шинжлэх ухаан, технологи, инновацын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

210402	Тээвэр, шатахуун	880,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,739,800.0</b>
210702	Дотоод албан томилолт	5,739,800.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,500,000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,715,150.0</b>
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,715,150.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,043,150.7</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,043,150.7</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,043,150.7
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>79,070,407.7</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>79,070,407.7</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>79,070,407.7</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	51,285,007.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,285,400.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,500,000.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Боловсролын газар /цаашид Боловсролын газар гэх/ нь 2024 онд “Иргэн бүрийг бие даан суралцах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, технологийг хүртээмжтэй, чанартай олгоно” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Салбарын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах, өөрчлөх, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох.
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх.
- Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох эрх зүйн баримт бичигт заасны дагуу эрх бүхий байгууллагад гаргаж өгөх.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
- Харьяаны ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загвар батлах.
- Шинжлэх ухаан, технологи, инновацын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдэж “шаардлагад нийцсэн” гэж дүгнэгдэн акт, албан шаардлага тогтоогдоогүй байна. Мөн байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Боловсролын газрын мөрдөж байгаа “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111,912.2 мянган төгрөгөөр буюу 1.0 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,500.0	-	(4,500.0)
Бараа материал	12,224.2	15,454.8	3,230.6
Үндсэн хөрөнгө	94,652.0	207,833.6	113,181.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>111,376.2</b>	<b>223,288.4</b>	<b>111,912.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	111,376.2	223,288.4	111,912.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>111,376.2</b>	<b>223,288.4</b>	<b>111,912.2</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Өмнөх онд үүссэн 4,500.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг Боловсролын ерөнхий газраас бүрэн барагдуулсан,
- Бараа материал дансны үлдэгдэл нь 15,454.8 мянган төгрөг болж, 3,230.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 37,182.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 1,500.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материалыг шилжүүлэн авсан болон 35,452.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,833.6 мянган төгрөг болж, 113,181.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,099.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, Боловсролын мэдээллийн төвөөс 16,080.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, 152,644.9 мянган төгрөгийн /46 нэр төрлийн 146 ширхэг/ тавилга, тоног төхөөрөмжийг дахин үнэлж орлогод авсан болон аймгийн ИТХ-ын 2024 оны 186 дугаар тогтоолоор 12,837.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталсан нь голлон нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,640,295.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 296,324.0 мянган төгрөгөөр бууруулан 8,343,971.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 326,443.0 мянган төгрөгөөр бууруулан зохицуулалт хийж, 8,017,528.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- *Ном хэвлэлийн зардлыг 175,091.2 мянган төгрөгөөр,*
- *Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 153,000.0 мянган төгрөгөөр,*
- *Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 107,255.0 мянган төгрөгөөр бууруулан эцэслэн баталсан байна.*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,017,528.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэн, гүйцэтгэлээр 7,823,453.5 мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,823,453.5 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь төсвийг 194,074.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	838,939.5	750,470.0	(88,469.5)	89.5
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	72,696.4	66,063.3	(6,633.1)	90.9
3	Сургуулийн өмнөх боловсрол-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,393,951.8	2,364,608.0	(29,343.8)	98.8
4	Ерөнхий боловсрол-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,711,940.4	4,642,312.2	(69,628.2)	98.5
	<b>Нийт</b>	<b>8,017,528.1</b>	<b>7,823,453.5</b>	<b>(194,074.6)</b>	<b>97.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн 100130015401 тоот дансанд нийт 79,070.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 74,027.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- *Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон 51,285.0 мянган төгрөгийг төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэлд олгосон,*
- *Өмнөх онд зарцуулалгүйгээр татан төвлөрүүлсэн 4,500.0 мянган төгрөгийг олимпиадын зардалд зарцуулсан,*
- *Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон 11,000.0 мянган төгрөгийг багш нарын бага хурал, сургалт, арга хэмжээний зардалд зарцуулсан,*
- *Боловсролын ерөнхий газраас шилжүүлсэн 12,285.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, 5,043.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Боловсролын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Иймд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 5,258,364.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **52,583.6** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Боловсролын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,815.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1,623.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2,630.1	1	2,630.1	100
	1	185.1	1	185.1	100
Албан шаардлага	1	123.8	1	123.8	100
	1	1,500.0	1	1,500.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>4,439.0</b>	<b>4</b>	<b>4,439.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын батлагдсан 30 орон тооноос нөхөгдөхгүй байгаа 10 ажлын байраас /дарга, физик, газарзүй, дизайн технологи, математик мэдээлэл зүй, мэдээллийн технологийн ажилтан зэрэг/ 7-г нь төрийн захиргааны албан хаагчаар хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл олгож байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн дараах заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

- 37 дугаар зүйлийн 37.1 дэх " Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7:"Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...." гэх мэт

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **39,835.6** мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс 38,310.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,525.6 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв.

##### 5.1 Албан шаардлага:

1. БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 9/2400 дугаар албан бичгийг үндэслэн тус байгууллагын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд батлагдсан төсвөөс Мандал сумын 7 цэцэрлэгт тус бүр 5,000.0 мянган төгрөг буюу нийт **35,000.0** мянган төгрөгийг шилжүүлж, тус газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Гэрээт ажлыг хүлээн авсан акт болон холбогдох бусад анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гэрээний дагуу гүйцэтгүүлсэн **3,000.0** мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- *Боловсролын яамнаас багш нарт олгогдсон 483 ширхэг хромбүүк-ийг лицензжүүлэх, үндсэн тохиргоо хийлгэх зорилгоор иргэн И.Батхүү-д 1,000.0 мянган төгрөг,*
- *Байгууллагын интернэт тоног төхөөрөмжийг суурилуулах, байрлуулах зорилгоор “Мэксим консалтинг”-д 2,000.0 мянган төгрөг гэх мэт.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сургалтын үйл ажиллагаанд оролцохоор аймгийн төвд албан томилолтоор ажилласан нэг байгууллагын дарга удирдлага, сургалтын менежер, арга зүйчдийн унааны зардлыг нэг тээврийн хэрэгслээр бус тус тусын тээврийн хэрэгслээр тооцон шатахууны зардлыг **310.0** мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зэрэг үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөлгүйгээр буюу анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр нийт **1,525.6** мянган төгрөгийн /сумдаас ирсэн сургууль, цэцэрлэгийн удирдлагад/ шатахуун зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ын НХМаягт ТМ-4 /жолоочийн тооцооны хуудас/-ийг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	35,000.0			1	35,000.0						
Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1	3,000.0			1	3,000.0						
Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулаагүй	1	310.0			1	310.0						
Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бүртгээгүй	1	1,525.6					1	1,525.6				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>39,835.6</b>			<b>3</b>	<b>38,310.0</b>	<b>1</b>	<b>1,525.6</b>				

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.